



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны
талаар авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалд тавигдах нийтлэг шаардлагыг нэгдүгээр, эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалыг үнэлэх үнэлгээний хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2 Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалын нэгдсэн сан байгуулан ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн (Б.Цогтбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн)-т даалгасугай.

СЛАЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТНЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080023

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 07 өдрийн
04 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалд
тавигдах нийтлэг шаардлага**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалын чанар, хүртээмжийг сайжруулахад энэхүү нийтлэг шаардлагын зорилго оршино.
- 1.2. Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материал нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

Хоёр. Бүтэц, агуулга

- 2.1. Мэдээллийн хэмжээ, багтаамж: Мэдээлэл нь богино, ойлгомжтой байна.
 - Богино үг эсвэл хоёр үетэй үг хэрэглэнэ.
 - Үгийн тоо урт өгүүлбэрт дээд тал нь 8-10 үгтэй байна.
 - Шинжлэх ухааны болон мэргэжлийн үг хэллэг хэрэглэхээс татгалзана.
 - Хүмүүсийн хамгийн сайн мэддэг үгийг сонгож текстэд ашиглана.
 - Тэмдэгтүүдийг хязгаартай хэрэглэнэ.
 - Тэмдэглэгээг хамтад нь хэрэглэнэ.
- 2.1. Мэдээллийн дараалал, байршуулсан хэлбэр:
 - Мэдээллийг хүн харахад илүү ойрхон, харахад хялбар байршуулсан байна. /Баруун гар талын доод талд байрлуулна/
 - Өгөх гэж буй мэдээллийн утга санаа нь бичиглэлээр байх нь илүү ойлгомжтой.
- 2.2. Сурталчилгааны материалын харагдах байдал нь хэт олон хурц өнгийг сонгохгүй байна.
- 2.3. Мэдээллийн зохион байгуулалт: Өгөх гэж байгаа мэдээлэл нь сайн, хялбар, ойлгомжтой, товч, тодорхой илэрхийлэгдсэн байна.
- 2.4. Сурталчилгааны материалыг тохиромжтой цаг үед нь зөв аргаар хүргэнэ.
- 2.5. Мэдээллийг цаг үе, нөхцөл байдалтай уялдуулна.
- 2.6. Мэдээллийг жижиг жижиг санаануудад хуваана.
- 2.7. Мэдээлэл, сурталчилгаа нь цахим хэлбэрээр байгаа үед хэдхэн секунд, хэдэн минут байна.
- 2.8. Анхаарал татахуйц байна.
 - Өнгө, үсгийн фонд
 - Дүрс график
 - Дуу чимээ оруулсан байдал
 - Хөгжим
 - Уриа дуудлага

- Шинэлэг сувгуудаар
 - Зорилтот бүлгүүдийг оролцуулж боловсруулсан байдал
- 2.9. Сурталчилгааны элемент бүр нь зорилтот бүлгийн хүн амын сонирхол, онцлогт тохирч нийцсэн байна.
- 2.10. Өгөх гэж буй мэдээлэл нь:
- дэс дараалалтай, эмх цэгцтэй,
 - итгэл төрүүлэхүйц,
 - үнэмшигдэхээр бодит,
 - давтан хэрэглэгдэх,
 - ойлгоход хялбар тодорхой,
 - өөрчлөлт хийх сэдлийг төрүүлэхүйц,
 - тодорхой бүлгийн хүн амд хамаатай,
 - уриалсан байх гэсэн онцлогуудыг агуулсан байх хэрэгтэй.
- 2.11. Хөгжилтэй мессеж уриалга хэрэглэнэ.
- 2.12. Айж түгшүүр төрүүлэхүйц утга, үг хэллэг, зураг агуулаагүй байна.
- 2.13. Нэг мэдээллийг олон янзаар сурталчилж болно.
- 2.14. Нэг дүрс-нэг чимээ, товч байх зарчим баримтална.
- 2.15. Урт жагсаалтаас зайлсхийнэ. /Богино жагсаалтдаа (3-7 хэсэг) сумтай, таслалгүй/
- 2.16. Хадмал орчуулгын үг хэллэгээс зайлсхийнэ.

Гурав. Мэдээлэл, сурталчилгааны материалд тавих лого

- 3.1. Логог эрүүл мэндийг дэмжих бүх уулзалт, семинар, хэвлэлийн хурал, зөвлөлгөөн зэрэг арга хэмжээнүүд, бүх төрлийн хэвлэмэл материалууд, сонин сэтгүүлийн нийтлэл, зурагт хуудас, телевизийн нэвтрүүлэг, богино хугацааны сэрэмжлүүлэгт хэрэглэж болно.
- 3.2. Хоёр болон хэд хэдэн логог зэрэгцүүлэн ашиглаж болно.
- 3.3. Логог зэрэгцүүлэн байрлуулж байгаа тохиолдолд зүүн захад нь боловсруулсан буюу тэргүүлэх байгууллагын логог, баруун захад нь хандивлагч байгууллага, дунд нь ЭМСЯ ны болон бусад оролцогч байгууллагын логог тус тус байрлуулна.

Дөрөв. Бичвэрийн үзэгдэх байдал

Мэдээллийн үсгийн хэмжээ, фонтын хэв маягийг зөв сонгосон байна.

- 4.1. Үсгийн хэмжээ 12-14 байна.
- 4.2. Гарчигт үсгийн хэмжээг текстнээс 2-оор илүү томруулж хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл текстийн үсгийн хэмжээ 12 бол гарчиг нь 14 байна.
- 4.3. Гарчиг болон дэд гарчигны хооронд зай үлдээнэ.
- 4.4. Үсгийн загвар нь хүний хараа булаах, оюун ухаанд хадгалагдахаар байна.
- 4.5. Монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу бичнэ.
- 4.6. Зарим чухал үгийг тодоор бичнэ.
- 4.7. Ташуу болон доогуур зураасыг аль болох ашиглахаас зайлсхийнэ.

- 4.8. Мэдээлэлд цэг, таслал, тэмдэг орхигдуулахаас зайлсхийнэ.
- 4.9. Уншихад хялбар үгс, томъёо ашиглах шаардлагатай.
- 4.10. Үндэслэлийг гэрэлтэй хэсэг дээр хар өнгөөр бичвэл зохино.
- 4.11. Чухал түлхүүр санааг илэрхийлсэн үгийн товч тайлбарыг оруулна.
 - Үзв, бүрэн өгүүлбэр бийл
 - Хүний сонирхлыг татахуйц тайлбарууд байх
- 4.12. Цагаан талбай их үлдээнэ. /Цагаан зай үлдээхгүйгээр хэтэрхий их дүрс, текст орсон тохиолдолд хүний харааны хүчин чадал гүйцэх боломжгүй, залхаана. Иймд мэргэжлийн график дизайнерууд хэвлэх материалын нэг хуудсанд 10-35 %-д нь цагаан зай үлдээхийг зөвлөдөг.

Тав. Үзүүлэнгийн харагдах байдал

- 5.1. Үзүүлэн, зурган материалын хамгийн сайн, тод ойлгомжтой хэлбэрийг ашиглана.
- 5.2. Энгийн зургийг ашиглана.
- 5.3. Үзүүлэн нь хурц тод, зөв өнгө, ялгаралтай байна.
- 5.4. Хэрэгцээгүй олон зураг, мэдээллээс зайлсхийнэ.
- 5.5. Үзүүлэнд дараалал, дугаарыг ашиглана.
- 5.6. Хэрэгцээтэй мэдээлэл дээрээ сум ашиглана.
- 5.7. Гол мэдээллийг хүснэгтэд байрлуулна.
- 5.8. Уншихад хялбар болгох зорилгоор “Баруун зах”-ыг ашиглана.
- 5.9. Холбоос зураг оруулна.
- 5.10. Дүрс зургийг тухайн нөхцөл байдалд тохирсон бодитой, өндөр чанарын дүрс зургийг ашиглана.
- 5.11. Хавтасны зураг, мессеж нь доторх агуулгыг бүрэн илэрхийлсэн байх ёстой.
- 5.12. Материалд оруулсан зураг, дүрслэл нь монгол хүний дүр төрх байвал илүү тохиромжтой.
- 5.13. Үзүүлэн материалд ёс заншил, арьс өнгө, насны бүлэг нь өөр янз бүрийн хүмүүсийг харуулж болно.

Зургаа. Зохиомж буюу загвар

- 6.1. Нэг л мэдээллийг тавина. /Харахад хэт олон хэд хэдэн мессежүүдийг зэрэг тавьсан тохиолдолд хүмүүс заримыг нь мартаж, эсвэл бүр бүх мессежийг санахгүй байж болно./
- 6.2. Холбоотой мэдээллүүд харахад ойролцоо байрлалд тодорхой тайлбартай байна.
- 6.3. Текстыг тайлбарла, эсвэл зурган үзүүлэн ашиглана.
- 6.4. Хийсвэр зүйлсийг тодорхой тайлбарлах хэрэгтэй.
- 6.5. Хүмүүст танил зураг болон тэмдэгт ашиглахыг эрэлхийлнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 07 өдрийн
04 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны материалыг
үнэлэх үнэлгээний хуудас**

Чанартай, сайн мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулсан эсэхийг дараах үнэлгээний хуудсаар үнэлнэ.

1. Утга санааны хувьд

- Нэг баримтанд ногдох гол санааны тоог 3 – 4-ийн дотор хязгаарласан эсэх?
 Тийм
 Үгүй
- Шаардлагагүй боловч "мэдэхэд илүүдэхгүй" мэдээллийг хассан эсэх?
 Тийм
 Үгүй
- Баримтны хамгийн чухал мэдээлэл эхлэл хэсэгт байгаа эсэх?
 Тийм
 Үгүй
- Төгсгөлд нь утга санаа давтагдсан эсэх?
 Тийм
 Үгүй
- Уншигчиддаа хандаж авч болох арга хэмжээ болон зан үйлийг тодорхойлж өгсөн эсэх?
 Тийм
 Үгүй
- Бэлэн болсон баримтаа дахин нягталсан эсэх?
 Тийм
 Үгүй

2. Бичвэрийн төрх:

- Баримтанд тань хоосон зай их байгаа эсэх? Мөр хоорондын зай 1.2 см-аас их үү?
 Тийм
 Үгүй
- Тэмдэгтийн хэмжээ хангалттай (12-оос дээш) эсэх?
 Тийм
 Үгүй
- Чухал мэдээллийг тодруулахын тулд тод, налуу болон хайрцаглах аргуудыг ашигласан эсэх?
 Тийм
 Үгүй

- Үргэлж Том үсгээр бичихээс зайлсхийсэн эсэх?
 Тийм
 Үгүй
- Бичвэрийг зүүн тийш зэрэгцүүлсэн эсэх?
 Тийм
 Үгүй
- Баганы хэмжээ нэг мөрөнд 40-50 тэмдэгттэй эсэх?
 Тийм
 Үгүй
- Бэлэн болсон баримтыг дахин нягталсан эсэх?
 Тийм
 Үгүй

3. Зураг дүрслэлүүд:

- Зорилтот хүн амд нүүр хэсэг нь таалагдсан эсэх?
 Тийм
 Үгүй
- Зорилтот бүлэгт гол санаа нь юу болохыг харуулж чадсан эсэх?
 Тийм
 Үгүй
- Дүрслэлүүд нь гоёл чимэглэлийн бус энгийн сургамжтай эсэх?
 Тийм
 Үгүй
- Зураг, дүрслэлүүд нь бичвэрт өгүүлэгдсэн санааг ойлгоход хялбарчлаж чадсан эсэх?
 Тийм
 Үгүй
- Зураг, дүрслэлүүд хамаатай бичвэртэйгээ ойрхон байрласан эсэх?
 Тийм
 Үгүй
- Зөвхөн тайлбарыг нь уншаад гол санааг ойлгож чадсан эсэх?
 Тийм
 Үгүй
- Бэлэн болсон баримтыг дахин нягталсан эсэх?
 Тийм
 Үгүй

4. Зохиомж ба загвар:

- Мэдээллийн эрэмбэ дараалал зорилтот бүлгийн хүн амд ялгаатай эсэх?
 Тийм
 Үгүй
- Гарчиг болон дэд гарчиг ашигласнаар мэдээллийн хэмжээ ихэссэн эсэх?
 Тийм

- Үгүй
- Жагсаалт гаргахад тоочсон тэмдэгт ашигласан эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Этгээд үг хэллэг болон албан ёсны хэллэг ашиглахаас зайлсхийсэн эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Албан ёсны болон шинжлэх ухааны хэллэгүүд тайлбарлагдсан эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Бодит нэр үгс, үйлдэх хэв болон богино үг хэллэг ашигласан эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Харилцан ярианы хэв маягтай эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Бэлэн болсон баримтаа дахин нягталсан эсэх?
 - Тийм
 - Үгүй

5. Хөрвүүлэг:

- Хэлбэр, агуулга нь соёл уламжлалтай нийлэмжтэй эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Зураг дүрслэлүүд нь соёл уламжлалтай нийлэмжтэй эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Бэлэн болсон баримтыг дахин нягталсан эсэх?
 - Тийм
 - Үгүй

6. Ойлгох:

- Баримтаа ойлгомжтой байх үүднээс тухайн хэлнийхээ онцлогыг судалсан эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Баримт бэлдэхээс зорилтот бүлэгт баримтыг нягталсан эсэх?
 - Тийм
 - Үгүй
- Бэлэн болсон баримтыг зорилтот бүлэгт дахин нягталсан эсэх?
 - Тийм
 - Үгүй